

Монгол Улсын Ерөнхийлөгчийн

2018 оны 1 дүгээр сарын 31-ний

өдрийн 09 дүгээр зарлигийн нэгдүгээр хавсралт

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН БЭЛГЭДЛИЙН

ЗАГВАР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Прокурорын байгууллагын бэлгэдэл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага болохын агуулгыг илэрхийлсэн байна.

1.2. Прокурорын байгууллагын бэлгэдлийг энэ журамд заасны дагуу хэрэглэнэ.

Хоёр.Прокурорын байгууллагын бэлгэдлийн загвар

2.1. Прокурорын байгууллагын бэлгэдэл нь дугуй хүрээтэй, алдрын цэцгийн навчин дээр суурилсан байх ба төв хэсэгт нь хууль цаазын сүр, хүчийг илэрхийлсэн монгол бамбай, сэлэм байна.

Прокурорын байгууллагыг үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг болохыг агуулсан мөнх хөх тэнгэрийг билэгдсэн өнгө бүхий бамбайн гол хэсэгт төрийн соёмбыг, бамбайг тойрсон хэсэгт дөрвөн зүг найман зовхисыг илэрхийлж 8 товхыг, ариун мөрийг билэгдсэн бамбайг тойрсон цагаан хүрээний баруун, зүүн хэсэгт “Монгол Улсын прокурор” гэж крилл, уйгаржин үсгээр шар өнгөөр бичсэн үгийг тус тус товойлгон дүрсэлнэ.

Бамбайн дээд хэсэгт сэлэмний бариул, доод хэсэгт сэлэмний үзүүрийг гаргасан байх ба сэлэмний үзүүрийн 2 хэсэгт тус бүр алдрын цэцгийн 9 ширхэг алтан шаргал навч байна.

2.2. Прокурорын байгууллагын бэлгэдэл нь дараах загвартай байна.



**Гурав. Прокурорын байгууллагын бэлгэдлийг
хэрэглэх журам**

3.1. Прокурорын байгууллагын бэлгэдлийн эх загварыг Улсын Ерөнхий прокурорын албан өрөөнд байрлуулна.

3.2. Прокурорын байгууллагын бэлгэдлийг дор дурдсан газар, зүйлд байрлуулж, хэрэглэнэ.

3.2.1. прокурорын албан өрөө;

3.2.2. прокурорын газрын албан байрны хаягжилт, хурал, зөвлөгөөн, хүндэтгэл, уулзалтын танхим;

3.2.2. прокурорын байгууллагын бэлэг, дурсгалын зүйлс, ном, сэтгүүл, цахим хуудасны нүүр, холбогдох баримт бичиг, хэвлэмэл хуудас;

3.2.3. прокурорын байгууллагын албаны автомашин;

3.2.4. прокурор, прокурорын байгууллагын ажилтны албан үнэмлэх, түүний хавтас;

3.2.5. прокурорын энгэрийн тэмдэг, прокурорын байгууллагын далбаа.

3.3. Прокурорын байгууллагын бэлгэдлийг прокурорын дүрэмт хувцсанд хэрэглэж болно.

Дөрөв.Бусад

4.1. Прокурорын байгууллага, прокурор, ажилтан нь прокурорын байгууллагын бэлгэдэлд хүндэтгэлтэй хандаж хэрэглэнэ.

4.2. Прокурорын байгууллагын бэлгэдлийн загварыг өөрчилж хэрэглэхийг хориглоно.

4.3. Прокурорын байгууллагын бэлгэдлийг албан үйл ажиллагаанд хэрэглэнэ.

4.4. Энэ журмын хэрэгжилтэнд Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газар хяналт тавьж ажиллана.

---oO---